

“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025.04.25

№ ХТ-25/01

Улаанбаатар хот

Огноо: **2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр**

Цаг: **10:00-12:40**

Хурал болсон газар: **“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн хурлын танхим**

Хурлын дарга: **Одончимэд Одбаяр /ТУЗ-ийн ердийн гишүүн/**

Хурлын нарын бичгийн дарга: **Д.Цэцгээ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/**

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: **44**

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: **96,138,217**

Хурлын ирц: **96.5%**

Хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай,
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсөв батлах тухай,
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай,

“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 10:00 цагт “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн хурлын танхимд явагдлаа. Хуралд хурлын дарга О.Одбаяр, ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл, ердийн гишүүн Д.Балжинням, Б.Золбоо, хараат бус гишүүн Б.Ганбаатар, Ч.Амарбаатар, Д.Балдорж, Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн болон компанийн удирдлагын багийн гишүүд биечлэн оролцлоо.

Хурлын дарга О.Одбаяр: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Миний бие “Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар томилогдсон. Ирцийн бүртгэлийн дүнг Тооллогын комиссоос танилцуулснаар хурал эхэлнэ.

Хурлын бүртгэлийг 10:00 цагт хааж, тооллогын комиссын дарга А.Энхзул хурлын ирцийн мэдээллийг хурлын даргад мэдээллээ.

Хурлын дарга О.Одбаяр: Компанийн саналын эрх бүхий хувьцааны 96.5 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцож, хурлыг хүчин төгөлдөр гэж үзсэн тул хурал нээснийг мэдэгдье.

- Хурлын дарга О.Одбаяр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг танилцууллаа.

Хурлын дарга О.Одбаяр: Хурлын дэгтэй холбоотой санал хүсэлт байхгүй тул хэлэлцэх асуудалтай холбоотойгоор компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн танилцуулна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1: Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн: ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл, хурлын дарга О.Одбаяр, хүндэт ТУЗ-ийн гишүүд болон энд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн мэнд хүргэе. Компанийн 2024 оны орлого, үр дүнгийн тайланг Earnings Call-оор, Монголын хөрөнгийн биржийн “А” самбарт бүртгэлтэй Top-20 индекст явдаг компанийн хувьд мөн онлайнгаар танилцуулсан. Өнөөдөр та бүхэнд 3 дахь удаагаа хүргэх гэж байна. Өнгөрсөн жил миний бие гүйцэтгэх захирлаар томилогдоод компанийн нөхцөл байдал болон 2024 онд хийх ажлуудаа танилцуулж байсан. Хувьцаа эзэмшигч нартаа ойлгуулах ёстой хэд хэдэн зүйл байна. Монгол шуудан ХК гэдэг өөрөө ямар компани юм бэ. Зүгээр нэг төрийн өмчийн оролцоотой компани уу,

эсвэл нээлттэй хувьцаат компани уу гээд ойлголтын зөрүүнүүд гардаг. Бид бүх нийтийн үйлчилгээний үүргийг Олон улсад болон Монгол улсад төрийн өмнөөс хүлээдэг. Монгол улсын Засгийн газар 1964 онд Дэлхийн шуудан холбооны байгууллагад элсэн орсноор Монгол шуудан компанийг энэ үүргээ хэрэгжүүлэхээр төлөөлөн томилсон байдаг. Тэр цагаас хойш бид энэ үүргээ биелүүлэн ажиллаж байна. 2 дах онцлог нь төрийн өмчийн давамгайлал оролцоотой компани. 2016 онд МУИХ, Засгийн газар, Төрийн өмчийн хороо, Монгол шуудан компанийн ТУЗ гэх мэт шат дараалсан шийдвэрийн дагуу 34 хувийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй зарлаж, олон нийтийн компани болгосон.

- Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн компанийн 2024 оны тайланг дэлгэрэнгүйгээр танилцууллаа.

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн: 2025 онд бид юу хийх вэ гэдгээ та бүхэнд товч танилцуулъя. 1-рт Хүчин чадал бүтээмж нэмэгдүүлэх. Үүний тул автоматжуулалт, орлого өндөртэй бизнесүүд рүү орох шаардлагатай болж байна. Бидэнд албан ёсны стандарт агуулахууд байхгүй. Үнийг яаж барих вэ, хаанаас санхүүжүүлэх вэ гэдэг нь маш чухал асуудал болж байна. Мөн ялган боловсруулах процессыг автоматжуулах ёстой. Бид өдөрт 12-13 мянган ширхэг шуудан ялган боловсруулж байна. Үүнийгээ бид гараар ялгадаг. Нэг сайн мэдээ дуулгахад Буянт-Ухаа терминал дээр 5 сарын дундуур бага оврын автомат ялган боловсруулах машин тавихаар боллоо. Хятадын талаас үйлдвэр дээр хийгдэж байгаа процессоо харуулсан. Үүнийг бид хөрөнгө оруулалтаар биш, хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд Хятадын талын хөрөнгө оруулалтаар хийх гэж байна. Үүнээс илүү том автоматжуулалтыг хийх зайлшгүй шаардлага гарч байна. Цахим шилжилтийг эрчимжүүлэх ёстой. Датанд суурилсан хэрэглэгчийн үйлчилгээ, хүргэлтийн оновчлол, гадаад цахим худалдааны платформуудтай мэдээллийн урсгалын холболтыг хийнэ. Эдгээрийн үр дүнд ялган боловсруулах төвийн хүчин чадал 5 дахин нэмэгдэнэ. Нэг ажилтны бүтээмж 69 хувиар нэмэгдэнэ. 2023 онд 1.6 сая төгрөгийн бүтээмжтэй байсан бол 2025 онд 2.7 сая төгрөгийн бүтээмжтэй болгох зорилт тавьж байна. Ажилтны тоог нэмэхгүй, мөн хасахгүйгээр бид хийнэ. Ажилтнуудаа сургана, мэргэшүүлнэ, өөр аргаар ажиллуулна. Энэ бүгдийг хийхийн тулд хэрэглэгч төвтэй үйлчилгээний шинэчлэлийг зайлшгүй хийх шаардлагатай. Хэрэглэгч хэзээ, хаана миний илгээмж явж байгааг өөрөө мэдэхийг хүсэж байна. Хэдэн цагт өөрийнх нь гар дээр ирэхийг мэдэхийг хүсэж байна. Сонголттой байхыг хүсэж байна. Бид 2025 онд үсрэлт хийхийг хүсэж байна. Үүний тулд гадаад бизнес, хил дамнасан цахим худалдааны стратегийн тоглогч болж нийлүүлэлтийн гинжин хэлхээний үнэ цэнэ бүхий оролцогч болохыг зорьж байна.

Хурлын дарга О.Одбаяр: Г.Тэлмэн захирал баярлалаа. Дэгийн дагуу эхний хэлэлцэх асуудалтай холбоотой дараагийн тайлангуудыг танилцуулаад явъя.

- ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга Д.Балдорж компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн аудитын хорооны дүгнэлтийг танилцууллаа.
- ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Золбоо компанийн 2023 оны ногдол ашиг тараасан тухай тайлан, 2024 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцууллаа.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Эрхэм хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн мэнд хүргэе. ТУЗ-ийн зүгээс КТХ заасан хугацаанд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа зарлан хуралдуулж байна.

- ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл ТУЗ-ийн 2024 оны тайлан, дүгнэлтийг дэлгэрэнгүйгээр танилцууллаа.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Монгол шуудан ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт КТХ заасны дагуу ТУЗ-ийн зүгээс нэгдмэл дүгнэлт өгч хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж байна. Төлөвлөсөн орлогын төлөвлөгөөг биелүүлсэн, санхүүгийн үзүүлэлтийн бүтцийн хувьд үндсэн үйл ажиллагаанаас анх удаа ашигтай ажилласан, гүйцэтгэх захирлаар ахлуулсан удирдлагын баг, компанийн хамт олон 2024 онд тавьсан зорилго, зорилтууддаа хүрэхийн тулд өрсөлдөх зэх зээл дээр сайн ажиллаж, орлогыг нэмэгдүүлэх,

зардлыг бууруулах арга хэмжээг авч, өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ашигласан учраас "Сайн" гэсэн дүгнэлтийг өгсөн. Энэ дүгнэлтийг баталж өгнө үү хэмээн хувьцаа эзэмшигчдийн хуралдаа танилцуулж байна.

Хурлын дарга О.Одбаяр: Д.Нарангэрэл захирал болон тайлан танилцуулсан бусад гишүүддээ баярлалаа. Хэлэлцэх асуудлын 1-р хэсэг дуусаж байна. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлттэй холбоотой тайлангуудаас асуух асуулттай хувьцаа эзэмшигч байна уу.

Төрийн өмчийн төлөөлөл: Сайн байцгаана уу. Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Миний бие төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийг төлөөлж оролцож байгаа А.Молор гэж хүн байна. Та бүхнээс санхүүгийн тайлантай холбоотой тодруулга авъя. 1-рт Дансны авлага өмнөх жилийн гүйцэтгэлээс 51 хувь өссөн шалтгаан. 2-рт Компани үндсэн үйл ажиллагаагаараа ашигтай ажиллаж эхэлсэн нь талархууштай байна. 2023 онд валютын ханшийн зөрүүнээс 5.4 тэрбум төгрөг олзтой ажилласан. Мөн өмнөх жилүүдэд дандаа олзтой гардаг байсан бол 2024 оны гүйцэтгэлийн хувьд валютын ханшийн гарзтай гарч ирсэн байна. Энэ ямар шалтгаантай вэ. 3-рт Д.Нарангэрэл даргын танилцуулгад 2024 оны гүйцэтгэлээр анх удаа үндсэн үйл ажиллагаанаас ашигтай ажиллаа гэж танилцуулсан. Үндсэн үйл ажиллагааны хувьд сүүлийн 5 жилд хэдэн төгрөгийн ашигтай ажиллаж байсан бэ. 5 жилийн дунджаар үндсэн үйл ажиллагааны цэвэр ашиг хэд вэ. 2024 онтой харьцуулж үзэхэд өсөлт бууралт нь хэд байгаа вэ. 4-рт Нэгж хувьцааны ногдол ашгийн өгөөж 2024 онд тодорхой шалтгааны улмаас нэг төгрөг болж буурсан байна. Үүнийг бол ойлгосон. Харин 5 жилээр нь харьцуулж үзэхэд ямар түвшинд байна вэ. 5-рт Мөнгөн хөрөнгө 2023 оноос 40 хувь буурсан байна. Сүүлийн 5 жилийн дунджаас 43 хувиар буурсан харагдаж байна. Буурах болсон шалтгаан юу вэ.

Хурлын дарга О.Одбаяр: Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн хариулна.

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн: Асуултуудад хариулъя. Үндсэн үйл ажиллагаанаас 2 тэрбум төгрөгийн ашигтай гарч байгаа нь анх удаа. 2023 онд үндсэн үйл ажиллагааны алдагдал 2.3 тэрбум байсан. Нэгж хувьцааны өгөөжийн хувьд 2024 онд 1.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай гарсан учраас хамгийн их буюу 6 төгрөгийн ногдол ашиг тараасан. 2016 оноос хойших дунджаар авч үзвэл 2-3 төгрөг байна. Ногдол ашгийн тайлан дээр Б.Золбоо гишүүн дэлгэрэнгүй судалгаа танилцуулсан. Нэгж хувьцааны өгөөж бага байгаа хэдий ч IPO хийж байх үед нэгж хувьцааны үнэлгээ 185 төгрөг байсан. Түүхэн дээд хэмжээ нь 1,900 төгрөг хүрч байсан. 2024 оны байдлаар 690 төгрөгөөр хаагдсан гэж үзвэл хувьцааны үнэлгээ өссөн харагдаж байна. Хувьцаанд хөрөнгө оруулж байгаа хүн бол 2 зүйл хардаг. Ногдол ашгийн өгөөж, хувьцааны үнэ цэнгийн үнэлгээний өгөөж. Үнэ цэнгийн үнэлгээний өгөөжийн хувьд 2016 онтой харьцуулахад хөрөнгийн биржийн өсөлттэй үед нь дагаад өсөж байсан. Монголын хөрөнгийн бирж өөрөө Дэлхийн хөрөнгийн биржийн шалгуураар дөнгөж эхэлж байгаа шинэ. Сайн мэдээ гарсан ч хувьцааны үнэ унаж байдаг, муу мэдээ гарсан ч өсөж байдаг. Оролцогч багатай. Компанийн мөнгөн хөрөнгө хил дамнасан дамжин өнгөрөх шуудан буюу транзит шуудангийн урсгалаас хамаарч байна. БНХАУ-аас ОХУ руу явах мөнгөн хөрөнгө манай дээр байршиж байгаад ОХУ руу төлөгддөг. Транзит шуудангийн хувьд 2023 оны 10 сараас бараг зогссон гэж хэлж болно. Өмнөх жилүүдтэй харьцуулахад багассан. Үүнийг дагаад Монгол шуудангаар дамжих мөнгөн хөрөнгө багасаж байна. Нөгөө талдаа богино хугацаат өглөг улс хоорондын шуудангийн төлбөр байдаг. Одоогийн байдлаар компани 7 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөтэй, 6 тэрбум төгрөгийн авлагатай, 11 тэрбум төгрөгийн өглөгтэй, 2 тэрбум төгрөгийн нэмэхтэй байна. Мөнгөн хөрөнгө компанийн хөрөнгийг жилээс жилд савлагаатай харагдуулдаг онцлогтой байгаа. Томоохон өглөг болох ОХУ-ын шуудангийн байгууллагад төлөх өр төлбөрийг 2023 оны 12 сарын 31-нээр тасалбар болгоод 5 сард акт үйлдэж хаасан. Улс хоорондын тооцоо он жил дамжиж хийгддэг. 2024 онд мөнгөн хөрөнгийн урсгал дээр багагүй дарамтууд байсан. Бид чадахаараа зохицуулаад төлбөрүүдийг төлөөд явсан.

Санхүү, төлөвлөлтийн газрын захирал Г.Ганчимэг: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Авлага 2.6 тэрбум төгрөгөөр өссөн. Гол шалтгаан бол улс хоорондын тооцооны авлага байдаг. Улс хоорондын тооцоо дараа жилийн эхний улиралдаа тооцогдож явдаг тул өндрөөр үүсэж явдаг.

Транзит шуудангийн тооцоо 2024 оны 08-12 сарынх буюу 2.5 тэрбум төгрөг байна. Энэ онд эхнээсээ орж ирж байна.

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн: Бид гадаад валютын ханшийн гарзгүй гарсан бол ашиг нэмэгдэх байсан болов уу. Энэ нь баланс гарч байх үеийн хэрэгжээгүй гарз байгаа. Цаашид бид ханшийн эрсдэлийн менежментийг сайн хийх зайлшгүй шаардлага гарч байна. Улс хоорондын бизнес эхлэх үед ханшийн эрсдэл зарим жилүүдэд олз болоод, зарим жилүүдэд гарз болж байгаа учраас зайлшгүй менежмент хийхийг ТУЗ-өөс ч үүрэг өгсөн, удирдлагын багийн зүгээс ч энэ тогтолцоог бүрдүүлэхийн төлөө ажиллаж байна.

ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч О.Чинхүсэл: Сайн байцгаана уу. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос асуулт асууя. ТУЗ-ийн ердийн гишүүдийн хувьд хувьцаа эзэмшигчдийн зүгээс нэр дэвшүүлээд явж байгаа байх. Хараат бус гишүүдийн асуудал дээр ямар байр суурьтай ажиллаж байгаа вэ. 1-рт Хараат бус гишүүн Банзрагч овогтой Ганбаатар гэдэг хүн 2020 оноос хойш ажиллаж байгаа юм байна. 5 жил дараалж ажиллах боломжтой байдаг уу. 2-рт Дарамбазар овогтой Балдорж гэдэг хүн 2018 оноос хойш хараат бус гишүүнээр ажилласан байна. 7 жил дараалан ажиллахаар хараат бусаар сонгогдож байна уу, үгүй юу гэдэг нь эргэлзээтэй байна.

Хурлын дарга О.Одбаяр: Асуултыг ойлголоо. Хэлэлцэх асуудлын 3 дээр ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай хэлэлцэгдэнэ. Тэр үед нь энэ хүний асуултад хариулъя. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хувьцаа эзэмшигчид батлах ёстой. Та бүхэн саналын хуудсаар саналаа өгөөрэй.

Өөр санал хүсэлт байхгүй гэснээр дараагийн хэлэлцэх асуудал руу орлоо.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 2: ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв батлах тухай;

Хурлын дарга О.Одбаяр: ТУЗ-ийн 2024 оны зардлын тайлан болон 2025 оны зардлын төсвийн мэдээллийг Цалин, урамшууллын хорооны гишүүн Б.Ганбаатар танилцуулна.

- ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Ганбаатар ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг танилцууллаа.

Хурлын дарга О.Одбаяр: Зардлын төсөвтэй холбоотой асуулт байна уу.

Өөр асуулт, санал хүсэлт байхгүй гэснээр дараагийн хэлэлцэх асуудал руу орлоо.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 3: ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай

Хурлын дарга О.Одбаяр: Нэр дэвшүүлэх түр хорооны гишүүн Д.Балжинням ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулна.

- Нэр дэвшүүлэх түр хорооны гишүүн Д.Балжинням ТУЗ-ийн ердийн гишүүн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй мэдээллийг танилцууллаа.

Нэр дэвшүүлэх түр хорооны гишүүн Д.Балжинням: ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшиж материалаа ирүүлсэн Жаргалсайхан овогтой Мөнхсайхан нь өөрийн хүсэлтээр нэрээ татсан. Нэр дэвшигч О.Чинхүсэлийн асуултад хариулъя. Нэр дэвшүүлэх үйл ажиллагаа зохих хууль, дүрмийн дагуу явагдсан. Сонгон шалгаруулалтын зар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон компанийн албан ёсны цахим хуудас, фэйс боок пэйж хуудсаар зарлагдсан. Ерөнхий болон тусгай шаардлага, бүрдүүлэх материалын жагсаалтын дагуу нэр дэвшигчид өөрсдөө сонирхлоо илэрхийлж материалаа ирүүлсэн. Нэр дэвшүүлэх түр хороо ирүүлсэн материалыг хянаад эдгээр хүмүүс хууль, журамд заасан шаардлагуудыг хангаж чадаж буй эсэхийг хянасан. Хурлын материалд орсон 2 нэр дэвшигч бүх шаардлагуудыг хангаж орж ирсэн. Тусгай болон ерөнхий шаардлага хангахгүй нэр дэвшигчдийг ийм үндэслэлээр та шаардлагыг хангаж чадсангүй гээд эхний шатны сонгон шалгаруулалт дээр хассан. Эдгээр 5 нэр дэвшигч хуулийн шаардлага хангачихсан, өөрсдөө саналаа илэрхийлэх эрхтэй. Энэ хүмүүсийг бид ийм

үндэслэлээр таныг нэр дэвшүүлэх боломжгүй гэж хэлэх эрх зүйн бололцоо байхгүй. Харин энэ хүмүүсийг сонгох уу, үгүй юу гэдгийг хувьцаа эзэмшигчид та бүхэн өөрсдөө шийднэ.

Хурлын дарга О.Одбаяр: Нэмж тодруулах зүйл байна уу. Өөр санал хүсэлт байхгүй бол 12:20 цаг хүртэл түр завсарлая. Хувьцаа эзэмшигчид саналын хуудсаа бөглөөд тооллогын комисст хүлээлгэн өгөөрэй. Саналын хуудас бөглөхтэй холбоотой тодруулах зүйл байвал тооллогын комиссын гишүүд тайлбар өгөөд явна.

Завсарлага 11:50 цагт эхэлж, 12:20 цагт дууслаа.

Хурлын дарга О.Одбаяр: Завсарлага дууссан тул хурлыг эхлүүлье. Тооллогын комиссын дүн танилцуулахаас өмнө төрийн өмчийн төлөөлөл А.Молор болон хувьцаа эзэмшигч Б.Амарбаатар санал хэлье гэж хүссэн. Эдгээр хувьцаа эзэмшигчдийнхээ саналыг сонсьё.

Төрийн өмчийн төлөөлөл: Компанийн 2024 оны тайлантай танилцаад төрийн өмчийн төлөөлөгчийн зүгээс дараах чиглэлийг ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад өгөх нь зүйтэй гэж үзэж байна. Компанийн санхүү эдийн засаг, нийгмийн үзүүлэлт, хувьцаа эзэмшигчдэд өгөх өгөөжийн үзүүлэлтийг богино, дунд, урт хугацаанд тогтвортой өсгөх чиглэлээр дараах арга хэмжээг авч ажиллах чиглэл өгч байна. 1-рт Орлогыг нэмэгдүүлэх, авлага, өглөгийг өмнөх үеийн гүйцэтгэлээс бууруулах, зорьсон төлөвлөгөөнд хүргэж ажиллах, 2-рт Зардлыг бууруулахтай холбоотой бодит үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Гүйцэтгэх захирлын тайланд дурдсанаар цахим шилжилт болон бүтээмж нэмэгдүүлэхтэй холбоотой боломжийн ажлууд төлөвлөөд явж байгаа гэж харлаа. Энэ ажлуудаа хэрэгжүүлээд ажиллаарай. Компанийн зардлын менежментэд нөлөөлөх, бууруулах ач холбогдолтой ажил гэж бодож байна. 3-рт Цэвэр ашиг, тэр дундаа нэгж хувьцаанд ногдох ашгийг богино хугацаандаа сүүлийн 5 жилийн дунджаас бууруулахгүй байх, цаашлаад дунд хугацаандаа энэ дунджаасаа давуулж биелүүлэх чиглэл өгч байна. 4-рт Валютын ханшийн зөрүүний алдагдлыг 2024 оноос хүлээгээд эхэлсэн байна. Валютын ханшийн менежмент дээр ТУЗ болон гүйцэтгэх удирдлага тодорхой арга хэмжээг авч ажиллаарай. 5-рт Үндсэн үйл ажиллагааны ашигт ажиллагаагаа дунд болон урт хугацаандаа тогтвортой, өсөлттэй байдлаар хангаж ажиллаарай. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг ерөнхийд нь "Компанийн засаглалын кодекс" хүрээнд үнэлээд, Санхүүгийн зохицуулах хорооноос хяналтын хороо ажиллуулаад явж байгаа. Компанийн хувьд 2023, 2024 оны байдлаар үзүүлэлт өсөж байна. Монгол шуудан ХК нь өөрөө төрийн өмчит компаниуд дотроо засаглалын түвшингөөрөө нэлээд дээгүүр ордог компани гэж үздэг. Иймээс компанийн засаглалын үнэлгээг 90-95 болгохыг чиглэл болгож байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Хурлын дарга О.Одбаяр: Төрийн төлөөллийн хэрэгжүүлж ирсэн төлөөлөл, одоо сонгогдох ТУЗ болон одоо ажиллаж байгаа гүйцэтгэх удирдлагад санхүүгийн үйл ажиллагаа дээр суурилсан тодорхой тоон үзүүлэлт дээр анхаараарай гэсэн чиглэл өгч байна. Энэ өгсөн чиглэлийг нийт хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хүлээн авч байна гэж хэлмээр байна. Миний хувьд жижиг хувьцаа эзэмшигчдийг төлөөлж ТУЗ-д суудаг. Өнгөрсөн хугацаанд төрийн өмчийн төлөөлөгчийн хэлсэн саналыг та бүхний өмнөөс ярьж, хэлж удирдлагын багт менежментийн үйл ажиллагаанд нь сайжруулах чиглэлээр зөвлөмжүүдийг өгч ажилласан хэдий ч цаашид илүү ажиллах ёстой. Монгол шуудан компанийн үйл ажиллагааг цаашдаа яаж сайжруулах вэ гэдэг дээр маш олон зүйлийг төлөвлөж хийх ёстой. Төр энэ зохицуулалттай зах зээл дээр ажиллаж байгаа биднийг дэмжээсэй гэж хүсэж байна. Төр малчид, тариаланчид, бусад боловсрол, эрүүл мэндийн салбарыг дэмжиж байна. Гэтэл үндсэн дэд бүтцийн салбар болох Монгол шууданг дэмжих хэрэгтэй байх. 330 суманд үйл ажиллагаа явуул гэдгийг төр шаарддаг. Бид бүх нийтийн үүрэг хүлээснээр тэндээс 3 тэрбум төгрөгийг алдагдал хүлээж, компанийн үйл ажиллагааны зардлаас зарцуулдаг. Иймээс Монгол шуудан ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн зүгээс гаргаж байгаа саналыг төрийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүд, төрийн төлөөлөл болж ирсэн төлөөлөл дамжуулж хэлж өгөөрэй. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийг харсан. Энэ жил 1 төгрөг буюу 99 сая төгрөг зарцуулахаар байна. Гэтэл өнөөдрийн 3 мянга гаруй хувьцаа эзэмшигчдэд хэдэн төгрөг оногдох вэ, 6 тэрбум төгрөгөөр хувьцаа худалдаж авсан Ард Санхүүгийн Нэгдэл ХК-д хэдэн төгрөг оногдох вэ, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ард байгаа 10 мянган хувьцаа эзэмшигчдэд юу оногдох вэ гэх мэт уялдаатай байгаа учраас төрийн өмчийн төлөөллөөс өгсөн

чиглэлийг хүлээн авч байна. Бид цаашид ашиг орлогоо нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах ёстой. Төрийн төлөөлөл ирсэн учраас энэ чиглэлээр та бүхэн хамтарч ажиллаарай гэж хүсье.

Хувьцаа эзэмшигч Ч.Амарбаатар: Монгол шуудан ХК-ийн хурал амжилттай сайхан болж байна. Гүйцэтгэх удирдлагын зүгээс хасах байсан үзүүлэлтийг дээшлүүлээд гаргаж ирлээ. Хамгийн чухал хэд хэдэн фактуудыг тодорхойгоор илэрхийлээд, бүтээмжийн асуудлыг ярилаа. Хөгжлийн асуудлыг бага зэрэг дурдаад өнгөрлөө. Хийсэн ажлаасаа илүү хийх ажил нь чухал байгаа учраас та бүхэнд саналаа хэлэхийг хүссэн. Дэлхий өөрөө асар хурдацтай өөрчлөгдөж байна. Энэ үед бид цаашаа юу хийх вэ. Монгол улс бүтээмжийн тухай огт ярьдаггүй, бизнесийг огт ойлгодоггүй. Бидний асуудлыг биш, масс хүмүүсийнхээ асуудлыг шийдэх гээд яваад байдаг. Маш олон байшин, сургууль цэцэрлэг баригдаад байдаг. Эдгээр нь хэдий хэрэгтэй ч мөнгө олох хэрэгтэй. Гэтэл мөнгө олдог боломжийг нь гаргаад ирэхээр бэлтгэлгүй учир хуучнаараа сэтгээд яваад байна. Иймээс хувьцаа эзэмшигчид та бүхэнд, шинээр сонгогдох ТУЗ, гүйцэтгэх удирдлагад хэлэхэд компанийн харьцаж байгаа түншүүд маань хязгааргүй их хөрөнгөтэй, компани эдгээр том компаниудтай энэ зэрэгцээд уулзах эрхтэй байгууллага. Тэнд 100 тэрбум долларын тухай ярьж байна. Гэтэл манай энд 6-7 сая долларын жижиг компани байна. Гэтэл төр гол хувьцааг нь эзэмшдэг. Төр шийдвэр гаргах гэж маш их уддаг. Гэтэл цаг хугацаа маш их хурдтай эргэлдэж байна. Дахиж бидэнд ийм боломж олдох эсэхийг мэдэхгүй байна. Өчигдөр би Г.Тэлмэн захиралтай уулзаад хурдтай байя, хурдтай шийдвэр гаргаад явъя гэсэн саналыг хэлсэн. Бүрэн ойлголцож чадаж байгаа. Иймээс гүйцэтгэх удирдлагын баг сайн ажиллана гэдэгт итгэлтэй байна. Монгол шуудангийн нэр бол маш супер брэнд нэр. Асар том ойлголт. Энэ брэндийг зөв хадгалаад явахын тулд хурдтай ажиллах шаардлага гараад байгаа учир Монгол шуудан компанийн оролцоотой бизнесүүдийнх нь оролцоотой, гадаад хөрөнгө оруулалттай компаниудыг байгуулж байж энэ эрх зүйт үйл ажиллагаа шийдэгдэх гэж байна. Монголд улсын хувьд хамгийн гайхамшигтай зүйл нь хязгааргүй эрх чөлөөтэй. Өөр ийм улс дэлхий дээр байдаг, үгүйг мэдэхгүй. Гэтэл 2 том хөрш маань маш том дүрэм журам доор байдаг. Тэд Монголоос мөнгө олох гэж орж ирэх гэж байгаа биш, гадагшаа гарч үзэх гэж Монголыг сонирхож байна. Иймээс бид богино хугацаанд шийдвэр гаргаж чаддаг системийг байгуулах шаардлагатай байна. Төрийн өмчийн төлөөлөл байж байгаад баяртай байна. Миний хувьд яагаад хувьцаа эзэмшигч болсон бэ гэхээр Монгол улсад байгаа хамгийн том брэнд. Монгол шуудан бол албан ёсны хувьцаат компани. Бид хувьцааг нь эзэмшигч. Гэтэл төрийн өмч давамгайлсан болохоор шийдвэрийг бид биш, төр гаргадаг. Харин манай ТУЗ-ийн дарга, гишүүд маш их нээлттэй учраас ямар нэг байдлаар ажлыг урагшлуулах гээд зүтгээд байна. Өнөөдөр Нарантуул руу, энэ олон захууд руу бүх зүйл каргоогоор орж ирдэг. Албан ёсоор татвар төлж бараа орж ирэхгүй байна. Карго авлига авах систем. Хурдтай байгаа нь үнэн. Гэхдээ стандартын бус. Урд талд манай гол түнш байна. Стандартын дагуу, хуулийн дагуу явъя гэж байна. Иймээс төр шийдвэрийг нь гаргаж өгөөд, төрийн өмч нь бидэнд итгээд боломжийг нь гаргаж өгөх хэрэгтэй болов уу гэж бодож байна.

Хурлын дарга О.Одбаяр: Ч.Амарбаатар захиралд баярлалаа. Монгол шууданд өөрөө хөрөнгөө оруулсан. Мөн компанийн төлөө санаа тавьж олон бизнесийн саналыг гаргадаг. Гүйцэтгэх удирдлагын зүгээс олон ажлуудыг хийгээд явж байгаа хэдий ч цаг хугацаа, 2 талын хамтын ажиллагаа, гуравдагч талын хамтын ажиллагаа гээд шийдэгдэх олон ажил байна. Мөн дээрээс нь хөрөнгө оруулалт хэрэгтэй. Бид болон хөрөнгө оруулагчид маань тэвчээртэйгээр компанийн төлөө санаа зовж, ажиллаж байгаа. Ч.Амарбаатар хувьцаа эзэмшигчийн хэлсэн үнэтэй саналуудыг удирдлагын баг үйл ажиллагаандаа төлөвлөөд, ТУЗ-өөрөө хэлэлцүүлэн батлуулаад, хэрэгжилт дээрээ хяналт тавиад, ирэх жилийн хувьцаа эзэмшигчдийнхээ хурлаар болж байгаа үйл явдлаа тайлбарлаад, болохгүй байгааг нь хэлээд явдаг системийг цаашид хадгалаад явах хэрэгтэй гэж үзэж байна. Тооллогын комисс саналын хуудсыг нэгтгэж дууссан тул тооллогын үр дүнд танилцуулна уу хэмээн дарга А.Энхзулыг урья.

- Тооллогын комиссын дарга А.Энхзул санал хураалтын дүн буюу тооллогын комиссын тогтоолыг танилцууллаа.

Хурлын дарга О.Одбаяр: Тооллогын комиссын даргад баярлалаа. Хурлаас гарах шийдвэрийн төслийг танилцуулъя.

- Хурлын дарга О.Одбаяр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрүүдийг танилцууллаа.

Хурлын дарга О.Одбаяр: Монгол шуудан ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 10:00 цагт "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ийн хурлын танхимд хуралдаж, 12:40 цагт үйл ажиллагаагаа амжилттай явуулж дууслаа. Та бүхэнд хурал хаасныг мэдэгдье. Хуралдаа оролцсон бүх хүмүүст баярлалаа. Бүгдэд нь ажлын амжилт, бизнесийн амжилтыг хүсэн ерөөе.

ХУРЛЫН ДАРГА:



О.ОДБАЯР

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

A handwritten signature in black ink, appearing to be "Д. Цэцгээ", is written next to the text "ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:".

Д.ЦЭЦГЭЭ